

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Европын эмэгтэйчүүдэд зориулсан залбирал

2025 он, шинэ он хаяанд ирлээ. Есүс шиг амьдрах хүч хаанаас ирдэг вэ? Бурхантай дотно харилцаж, өөрсдийгөө хайр, дуулгавартай байдлаар даруухнаар Түүнд өргөцгөөе. Тэгвэл бидний доторх Ариун Сүнс бидэнд хүч чадлыг өгөх болно. “Харин чи юу сурсан, юунд итгэсэндээ бай. Чи хэнээс сурснаа мэдэх бөгөөд Христ Есүс дэх итгэлээр авралд чамайг мэргэн болгох чадалтай ариун судар бичгүүдийг чи хүүхэд байхаасаа мэдсэн” 2Тимот 3:14-15. 2025 он зөвхөн Эзэний сайн сайхан хийгээд гоо үзэсгэлэнг харж, Түүнтэй хамт алхах жил байх болтугай.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Эзэн минь, "Нууцлагдсан эрдэнэс" аудио жүжгийн 2-р хэсгийг бүтээж буй багийнханд мэргэн ухаан, бүтээлч сэтгэлгээ өгч, олон эмэгтэйчүүдийг аврах болтугай. (2 Кор. 5:17)
2. Эзэн минь, Албани дахь манай баг гэр бүлийн хүчирхийллээс гарч буй эмэгтэйчүүдэд туслаж, тэднийг Есүсийн тухай сайн мэдээг хүргэж, орон нутгийн сүмтэй холбоо тогтоох боломжийг олгооч. (Евр. 13:16)
3. Аав аа, Хорватын христд итгэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлж, итгэлээрээ бэхжих харилцааг бий болгоход туслаач. (1 Тес. 5:11)
4. Эзэн минь, Данийн охидыг хүйсийн талаарх төөрөгдлөөс гаргаж, Таны төрхөөр бүтээгдсэн жинхэнэ дүр төрхөө хүлээн авахад нь туслаач. (Эх. 1:27)

5. Эзэн минь, Финляндын TWR Women of Hope байгууллагын 25 жилийн ойг тэмдэглэж байгаа залбирлын бэлгүүдийн төлөө талархан залбирч байна. (Евр. 3:22-23)
6. Аав аа, Францад итгэлээрээ хавчигдаж байгаа христэд итгэгчид болон еврей хүмүүсийг Та хамгаалж, хавчж байгаа хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөх болтугай. (Дуулал 140:1)
7. Бурхан минь, Германы улаан дэнлүүний гудамжинд хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн амьдралыг шинэчилж, шинэ амьдрал эхлүүлэхэд нь туслаач. (Дуулал 119:134)
8. Есүс ээ, Гренландын хүмүүсийг архи, мансууруулах бодисоос чөлөөлж, Таны гэрэл тэдний харанхуй хэсэгт тусаж, амьдралыг нь шинэчлэх болтугай. (Иох. 8:12)
9. Эзэн минь, Нидерландад сэтгэл гутралд өртсөн өсвөр насны охид шаардлагатай бүх тусламжийг авч, Есүсээс жинхэнэ тайвшрал, амар амгаланг олох болтугай. (Мат 11:28)
10. Аав аа, Хойд Кавказын эмэгтэйчүүдийг нийгмийн боломж гэр бүлийн шүүмжлэлээс чөлөөлж, Христийг дагана, итгэлийнхээ талаар гэрчилж, зоригтойгоор өөрсдийгөө илэрхийлэх чадвартай болгох болтугай. (Иса. 41:13)
11. Эзэн минь, Хойд Македони дахь "Хайрлагдсан, үнэ цэнэтэй нэгэн" хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн зүрх сэтгэлд хүрч, тэднийг найдвар, эдгэрэл, эрх чөлөөг өгч, Есүсийг дагадаг эмэгтэйчүүдэд туслах болтугай. (Дуулал 34:18)
12. Эзэн минь, Норвегид Христэд итгэгч эмэгтэйчүүд бусад орноос ирсэн эмэгтэйчүүдийг халамжилж, тэдний хэлний болон соёлын саад бэрхшээл, ганцаардал, гадуурхалтыг даван туулж, дулаан хүлээн авах болтугай. (Лев. 19:34)
13. Эзэн минь, Польшийн удирдагчид болон улс төрийн сөрөг хүчинд мэргэн ухаан, шийдвэр гаргах чадварыг өгч, улс орноо хамтран удирдах боломжийг олгооч. (Еврэй. 29:7)
14. Эзэн минь, Португалийн эмэгтэйчүүдийн ажлын нөхцөл байдал сайжирч, нийгэмд илүү тэгш боломж олдож, шударга цалин авдаг болох болтугай. (Дуулал 34:15)
15. Аав аа, Румынд гэр бүл салалт нэмэгдэж байна. Сахлаар шийдсэн хосууд гэр бүлээ аврахын тулд шийдвэрээ өөрчлөхөд нь туслаач. (Марк 10:9)

16. Бурхан минь, Оросын эмэгтэйчүүд Тантай харилцах хувийн харилцаандаа итгэлээ бэхжүүлж, Таны хүчээр амьдралдаа тайтгарлыг олдог болох болтугай. (Ефес. 3:16)

17. Эзэн минь, Сербийн гэр бүлүүдэд амар амгалан, эв нэгдлийг авчирч, эмэгтэйчүүдийг Христэд найдвар, хайр, ойлголтыг тээж, итгэлийг нь бэхжүүлж, үнэ цэнийг нь таних болтугай. (1 Петр 3:9)

18. Аав аа, Испанид амиа хорлох тохиолдол өсч байгаа энэ үед өсвөр насны охидууд нийгмийн сүлжээний хэт өндөр стандартуудаас сэтгэл зүрхээ хамгаалах мэргэн ухааныг олох болтугай. (Дуулал 147:3)

19. Эзэн минь, Албанид эцэг эхээсээ өнчирч, орхигдсон хүүхдүүдийн төлөө залбирч байна. Сүм чуулган тэдэнд Есүсийн хайр энэрэлээр хандах болтугай. (Дэд хуул ь. 10:18)

20. Аав аа, "Arise and Shine" хөтөлбөр нь Бельги, Нидерландад дах эмэгтэйчүүдийн сэтгэл зүрхэнд хүрч, итгэлээ гэрчлэн амьдрахад нь туслах болтугай. (Иса. 60:1)

21. Эзэн минь, Хорватын эмэгтэйчүүдийг Тэдний үнэ цэнийг Христ дотор хүлээн зөвшөөрч, айдас, эргэлзээнээсээ чөлөөлөгдөж, Таны хүчээр эрх чөлөөтэй, өөртөө итгэлтэй болоход нь Та туслаач. (Матай 10:31)

22. Эзэн минь, Данид хүлээн зөвшөөрөгдөхгүй, хүчирхийлэл, ганцаардал, өлсгөлөн, гэр оронгүй байдалд айдастай байгаа эмэгтэйчүүдэд хамгаалалт болон хангалтыг Та өгөх болтугай. (Дуулал 18:2)

23. Аав аа, Фарэйн арлууд дахь мансууруулах бодис, архины хэрэглээг таслан зогсоож, үүнээс шалтгаалан салсан гэр бүлүүдийг дахин сэргээн босгоход Таны хайраар эдгэрэл хайрлаарай. (Иох. 3:16)

24. Эзэн минь, Францын иргэдийн дийлэнхи нь Есүсиг үгүйсгэж байгаа энэ үед жинхэнэ итгэгчид Таны хайр ба үнэнийг дамжуулан, үл итгэгч хүмүүст Таныг гэрчлэх болтугай. (Лук. 18:8)

25. Бурхан минь, Германы залбирлын бүлгүүдийн залбиралын баг болон хандивлагчдын төлөө бид талархаж байна. Тэдэнд Найдвар доторх эмэгтэйчүүд хөтөлбөрүүдийг олон хэлээр дамжуулах оломжийг олгож байгаад баярлалаа. (Филип. 1:3-5)

26. Эзэн минь, Норвегид байгаа залбирлын багийн эмэгтэйчүүд баяр баясгалан болон гунигтай мөчүүдээ хуваалцан, бие биенээ урамшуулж, дэлхий даяарх эмэгтэйчүүдийн төлөө залбирах боломжийг олгооч. (Матай 18:20)

27. Аав аа, Польшийн сургалтын хөтөлбөрүүдээр дамжуулан гэр бүлийн зөв загварыг бэхжүүлж, Таны хүслийн дагуу боловсрол олгоход тусалж байгаад талархан залбирч байна. (Матай 19:4-5)

28. Эзэн минь, Португалийн эмэгтэйчүүд гэр бүл, ажил мэргэжлийн дундах амьдралдаа тэнцвэртэй байдлыг бий болгож чадахгүй байх энэ үедээ Таны үг, амралтыг олж чаддаг болох болтугай. (Матай 11:29)

29. Бурхан минь, Румын эмэгтэйчүүд эдийн засгийн энэ хүнд нөхцөлд Танаас ирсэн бүх зүйлийн төлөө талархаж, Танд найдах болтугай. (Иаков 1:17)

30. Аав аа, Сербийн багийн ухаалаг шийдвэрүүдийг гаргаж, шинээр бүтээж байгаа хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн амьдралыг эерэгээр өөрчлөх сэдэл, сэдвүүдийг сонгоход тусалж өгөөрэй. (Иаков 1:5)

31. Эзэн минь, Испанид хүүхэд тээх чадваргүйгээсээ болж ганцаардсан эмэгтэйчүүд Танаас итгэл найдварыг олж авах болтугай. (Дуулал 32:8)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Аав аа, бяцхан хүүхдүүдийг ханиад томууны дэгдэлтээс Та хамгаалаач
2. Бурхан минь Монгол улсад өдөр өсөж байгаа өргөн хэрэглээний бараа, тог цахилгаан болон бусад хүний нэн тэргүүний хэрэгцээтэй зүйлсийн үнэ тогтвортой байхад Аав аа Та бүгдийг хяналтандаа авах болтугай.
3. Бурхан минь Монгол улсын боловсролын системд шинэчлэл хийгдэж, хүүхдүүд үнэнийг зааж, үнэн рүү хөтлөх болтугай. Христэд итгэгч багш нар шударга байдал болон энэрэнгүй байдлаа, итгэлээсээ ичихгүйгээр ажиллах болтугай.

후원안내

**국민은행 851-01-0003-724 북방선교방송
최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.**